



**МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ОРОН НУТАГ ДАХЬ
САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ**

**Улаанбаатар хот
2014 он**

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 3 дугаар
сарын 1-ний өдөр

Дугаар 36

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.7, 48.10, Монголын Хуульчдын холбооны дүрмийн 4.6 дугаар зүйлийн 4, 4.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус удирдлага болгон Хуульчдын холбооны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.9.10 дахь заалт, Монголын Хуульчдын холбооны дүрмийн 9.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн “Монголын Хуульчдын холбооны орон нутаг дахь салбарын үйл ажиллагааны журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэ тогтоолыг 2014 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ

Д.БАТСҮХ

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ОРОН НУТАГ ДАХЬ САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 дүгээр зүйл. Ерөнхий зүйл

1. Энэ журмаар Монголын Хуульчдын холбоо /цаашид “Холбоо” гэх /-ны орон нутаг дахь салбарын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, Холбоо, орон нутагт хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хуульчдын хоорондын харилцааг зохицуулна.

1.2 дугаар зүйл. Салбарын үйл ажиллагаанд баримтлах зарчим

1. Салбарын үйл ажиллагаа нь хууль дээдлэх, хамтран ажиллах, ил тод байх, гишүүд санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, Холбооны үйл ажиллагаа гишүүдэд тэгш, хүртээмжтэй хүрч байх зарчимд үндэслэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ САЛБАРЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1 дүгээр зүйл. Салбарын зохион байгуулалтын хэлбэр

1. Салбар нь орон нутагт Холбооны нэрийн өмнөөс, түүнээс олгосон эрх хэмжээ, чиглэлийн хүрээнд үйл ажиллагаа явуулах бүтцийн нэгж байна.

2. Холбооны салбарыг Монгол Улсын аймаг бүрт ажиллуулна. Салбар байгуулах шийдвэрийг Холбооны зөвлөл гаргана.

3. Тухайн сум дахь хуульчдын тооноос хамаарч Холбооны зөвлөлийн шийдвэрээр сумд салбар байгуулж болно.

2.2 дугаар зүйл. Салбарын үйл ажиллагааны санхүүжилт

1. Салбараар дамжуулан зохион байгуулж буй үйл ажиллагааны санхүүжилтыг Холбоо хариуцна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЭРХЛЭН ЯВУУЛАХ

3.1 дүгээр зүйл. Салбарын зохицуулагч

1. Салбарын үйл ажиллагааг тухайн орон нутгийн хуульчдаас сонгогдсон зохицуулагч эрхлэн явуулна. Салбарын зохицуулагч нь хуульч байна.

[/Энэ хэсгийг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2016 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын 5 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/](#)

2. Салбарын зохицуулагчийг сонгох санал хураалтыг нууц санал хураалтаар явуулах бөгөөд олонхийн санал авсан нэр дэвшигчийг салбарын зохицуулагчаар сонгогдсонд тооцно.

/Энэ хэсгийг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2016 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын 5 дугаар тогтоолоор нэмсэн/

3.Салбарын зохицуулагчийг сонгох сонгуулийг Холбооны Тамгын газар зохион байгуулна.

/Энэ хэсгийг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2016 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын 5 дугаар тогтоолоор нэмсэн/

4.Салбарын зохицуулагчтай гэрээ байгуулан ажиллах бөгөөд энэ зүйлийн 2-т заасан санал хураалтын дүнг үндэслэн салбарын зохицуулагчийг Холбооны Ерөнхийлөгч 2 жилийн хугацаагаар томилно.

/Энэ хэсгийг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2016 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын 5 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/

5.Салбарын зохицуулагчийн урамшууллын хэмжээг тухайн салбарт харьяалагдаж байгаа хуульчдын тоог харгалзан Холбооны зөвлөл тогтооно.

/Энэ зүйлийн 4, 5 дахь хэсгийн дугаарлалтыг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2016 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын 5 дугаар тогтоолоор өөрчилсөн/

3.2 дугаар зүйл.Салбарын зохицуулагчийн чиг үүрэг

1.Салбарын зохицуулагч нь дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1.1.хариуцсан салбар дахь хуульчдыг хууль, Холбооны дүрэмд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

1.2.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Холбооны дүрэм, Холбооноос баталсан бусад дүрэм, журмыг тухайн орон нутагт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тэдгээрийг боловсронгуй болгох тухай өөрийн болон харьяа хуульчдын саналыг Холбоонд уламжлах;

1.3.хуульчийн Холбооны өмнө хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавьж, зөрчлийг арилгуулах ажлыг зохион байгуулах;

1.4.Холбооны үйл ажиллагааг орон нутагт сурталчлах, мэдээлэх;

1.5.тухайн орон нутагт тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа хуульчдын бүртгэлийг хөтлөх;

1.6.Холбоо, түүний эрх бүхий этгээдээс өгсөн бусад үүрэг, даалгаврыг биелүүлэх.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ ГИШҮҮНИЙ ОРОЛЦОО

4.1 дүгээр зүйл.Хуульч орон нутгийн салбарт бүртгэгдэх

1.Холбооны салбар байрлаж буй орон нутагт 2 жилээс дээш хугацаагаар оршин сууж, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хуульч нь тухайн салбарт харьяалагдаж болно.

2.Хуульч орон нутгийн салбарт бүртгэгдсэнээр тухайн орон нутгийн салбараар дамжуулан үйлчилгээ авах эрх үүснэ.

3.Холбооны эрх бүхий этгээдийн зөвшөөрөл, өгсөн үүргийн дагуу салбарын бүртгэлд хамрагдаагүй хуульчид, тухайн салбарт үйлчилгээ үзүүлж болно.

4.2 дугаар зүйл.Салбарын үйл ажиллагааны талаар хуульчийн эдлэх эрх, хүлээх үүрэг

1.Тухайн салбарт харьяалагдаж буй хуульч нь салбарын зохицуулагчаар дамжуулан Холбооноос үзүүлэх үйлчилгээ, мэдээлэл авах, салбараар дамжуулан Холбооны гишүүний эрхээ хэрэгжүүлнэ.

2.Салбарын зохицуулагчийн үйл ажиллагаанд дэмжлэг туслалцаа үзүүлж, энэ журам болон Холбооны дүрэм, бусад дүрэм, журамд заасан эрхийн хүрээнд тавьсан шаардлагыг биелүүлэх, гишүүн, хуульчийн үүргийн зөрчил, дутагдлыг арилгах, хууль зөрчсөн үйл ажиллагааг зогсоох үүрэгтэй.

ТАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

5.1 дүгээр зүйл.Журам хүчин төгөлдөр болох

1.Энэ журмыг 2014 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.